Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/149 дугаар тушаалын 15 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

**Байгууллагын нэр:** Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

**Нэгжийн нэр:** Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

**Албан тушаалын нэр:** Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

**Албан тушаалын ангилал, зэрэглэл:** Дэс түшмэл, ТЗ-5

**Ажлын цаг:** Ажлын өдөр 8 цаг

**Ажлын байрны албан ёсны байршил:** Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг

**Хөдөлмөрийн нөхцөл:** Хэвийн

**Онцгой нөхцөл:** Хамаарахгүй.

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, бодлого, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн боловсрол, дадал хэвшил олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Олон нийтэд чиглэсэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах.
2. Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх, идэвхжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх ажлыг нийгэм-сэтгэлзүйн хэрэгцээнд тулгуурлан олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах, мэргэжил арга зүй удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих, үр дүнг тооцох.
3. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч, эвсэл, бүлгүүдийг сургаж, чадавхжуулах, идэвхжүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх.
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Хүн амын дунд тэргүүлж буй өвчлөл, нас баралтанд дүгнэлт хийж, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг тооцох; | Үйл ажиллагааны тоогоор, | Г, Т |
| | 2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, тэдний хэрэгцээ шаардлагыг нас, хүйс, мэргэжил, ахуйн амьдрал, эрүүл мэндийн байдалтай нь холбон судлах ажлыг зохион байгуулж, хэрэгцээг тодорхойлон эрүүл мэндийн сургалтын агуулга, арга зүйг боловсруулж, тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах; | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар, | Т, Г |
| | 3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах, хянах, нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг тооцох; | Сургалт сурталчилгааны тоогоор, | Т, Г |
| | 4. Эрүүл мэндийн зөвлөгөө, | Олон нийтийн | |

| | | | |
|---|---|---|---|
| | сургалт, мэдээллийг олон нийтийн сүлжээнүүдэд байршуулж, иргэдэд сурталчлах, ЭМГ-ын сошиал хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх. | сулжээнд байршуулсан мэдээлийн тоогоор, | Т, Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, айл өрх, иргэнийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлэн, шалгаруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;<br>2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олны туршлагыг аймгийн хэмжээнд түгээн өргөжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах;<br>3. Эрүүл мэндтэй холбоотой нийгэм, сэтгэл зүйн хэрэгцээнд чиглэсэн үйлчилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцох. | Мэргэжил арга зүйгээр хангасан байгууллагын тоогоор,<br>Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор,<br>Судалгаа шинжилгээний ажлын тоогоор, | Т, Г<br>Г, Т<br>Г, Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч багш бэлтгэх, мэргэжлийн удирдлага, аргазүйгээр хангаж хамтран ажиллах;<br>2. Эрүүл мэндийн сайн дурын бүлгүүд, ажилтнуудыг чадавхжуулах, идэвхжүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх;<br>3. Эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай болон эрсдэлт бүлгийн иргэдэд зан үйлийг төлөвшүүлэх, өөрчлөх заслын, дэмжих, өөртөө туслах бүлэг ажиллуулахад мэргэжил арга зүйгээр хангах;<br>4. Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах, үйл ажиллагааг олон нийтэд ухуулан таниулах, үр дүнг нэмэгдүүлэхэд нөлөөлөх. | Бэлтгэгдсэн СДИ, үетэнгийн сургагч багшийн тоогоор,<br>Чадавхжуулах үйл ажиллагааны тоогоор,<br>Мэргэжил арга зүйгээр хангасан бүлгийн тоогоор,<br>Үйл ажиллагааны тоогоор, | Г, Т<br>Г, Т<br>Г, Т<br>Т, Г |
| | 1. Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;<br>2. Архив, албан хэрэг хөтлөлтийн | Үүрэг даалгаврын хэрэгжилтээр,<br>Стандартыг мөрдөж | Г |

| | | | |
|---|---|---|---|
| 4 дүгээр зорилтын хүрээнд | стандарт, журмыг мөрдөж ажиллах; | ажилласан байна. | Г |
| | 3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох; | Оролцсон арга хэмжээний тоогоор, | Г |
| | 4. Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; | Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Г |
| | 5. Жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах; | Зөрчилгүй байна. | Г |
| | 6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцан ажиллах. | Хэрэгжилтийн хувиар, | Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | Эрүүл мэнд /091/, багш эрүүл мэндийн боловсрол /011412/. | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;<br>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах; |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| | | - бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- нээлттэй, шударга байх;<br>- бусад. |
| | Бусад | - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх,<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;<br>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</u>

Эрүүл мэндийн газрын дарга.

| | |
|---|---|
| <u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u><br>Байхгүй. | <u>Бусад харилцах субъект :</u><br>- Эрүүл мэндийн яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,<br>- Аймгийн Засаг даргын орлогч,<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,<br>- Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд,<br>- Иргэн, хуулийн этгээд. |

## V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| <u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> | <u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> |

| Албан тушаал: ЭРҮҮЛ МЭНДИЙН НАЗРЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........... Н.ОЮУНТУЯА 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдөр | Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 2019.10.30 Дугаар: 201 |
| --- | --- |
| **VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:** | |
| Байгууллагын нэр: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2019.11.22 Дугаар: А/49 ДАРГА ........................... Д.ШИВААННҮРДЭВ 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдөр | |